



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/021/НА-СТА-ОНӨТҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
	Утас: 70007734      Цахим хаяг: <a href="mailto:Nandinjargalg@audit.gov.mn">Nandinjargalg@audit.gov.mn</a> Г.Нандинжаргал
	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Утас: 327734      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Утас: 315558      Цахим хаяг: <a href="mailto:gantugss@audit.gov.mn">gantugss@audit.gov.mn</a> Х.Түвшинбаяр С.Гантөгс
	Ахлах аудитор: Утас: 325093      Цахим хаяг: <a href="mailto:badamkhatann@audit.gov.mn">badamkhatann@audit.gov.mn</a> Н.Бадамхатан
Аудитор: Утас: 325093      Цахим хаяг: <a href="mailto:tsend-ayushts@audit.gov.mn">tsend-ayushts@audit.gov.mn</a> Ц.Цэнд-Аюуш	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
**НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,  
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 898  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙТЛЭГ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ОНӨТҮГ-ЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ш.МӨНХ-ОРГИЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл” хэсэгт тайлбарласан зүйлсийн нөлөөг эс тооцвол тус байгууллагын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар 481.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь шууд худалдан авалтаар бараа, ажил, үйлчилгээ авсан, тооцоо нийлсэн акт үйлдээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасантай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨААТҮГ нь Чингэлтэй дүүргийн 7, 19,16, 23 дугаар хороодын гадна фасад, 11, 16, 23 дугаар хороодын дотор засварын ажил, 7,16,18,20,21,22 дугаар хороодод гэрэлтүүлгийн ажлыг тус тус хийж 580.9 сая төгрөгийн зардал гаргасан байна.

C:\Users\narangua.j\Desktop\Бичвэр\Хяналт\2026\2025\word\ийвээн бичиг\Дүгнэлт\_2026.docx

1426051977

### Аудитын гол асуудал

Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨААТҮГ-ын 2025 оны төсвийг дүүргийн ИТХ-ын 2024 оны 14 дүгээр тогтоолоор 2,867.5 сая төгрөгөөр баталсныг дахин тодотгол хийж, 2025 оны 16 дугаар тогтоолоор 65.0 хувиар нэмэгдүүлэн 4,732.5 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх оны батлагдсан төсвөөс 9.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1.ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1.Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		
1.1.2. Дансны авлага		
1.1.3. Татвар НДШ-ийн авлага		
1.1.4. Бусад авлага		
1.1.5.Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6.Бараа материал	791,261,850.15	542,633,409.59
1.1.7. Урьдчилж төлсөн зардал/ тооцоо		
1.1.8. Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
1.1.10		
<b>1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	791,261,850.15	542,633,409.59
1.2. Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1 Үндсэн хөрөнгө	4,756,808,603.74 0	5,966,533,604.80
1.2.2 Биет бус хөрөнгө	859,146,076.44	868,749.99
1.2.3 Биологийн хөрөнгө		
1.2.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6 Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8 Бусад эргэлтийн бус хөрөнгө		
<b>1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	5,615,954,680.18	5,967,402,354.79
<b>1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,407,216,530.33</b>	<b>6,510,035,764.38</b>
<b>2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1 Өр төлбөр</b>		
<b>2.1.1 Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1 Дансны өглөг	37,803,200.00	14,258,170.00
2.1.1.2 Цалингийн өглөг		
2.1.1.3 Татварын өр		
2.1.1.4 НДШ-ийн өр		
2.1.1.5 Банкны богино хугацаат зээл		
2.1.1.6 Хүүгийн өглөг		
2.1.1.7 Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8 Урьдчилж орсон орлого		
2.1.1.9 Нөөц өр төлбөр		
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11 Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөд хам		
<b>2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>37,803,200.00</b>	<b>14,258,170.00</b>
2.1.2 Урт хугацаат өр төлбөр		

2.1.2.1 Урт хугацаат зээл		
2.1.2.2 Нөөц өр төлбөр		
2.1.2.3 Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5 Зээл		
2.1.2.6 Хойшлогдсон өр төлбөр		
<b>2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2 Өр төлбөрийн нийт дүн</b>		
2.3 Эздийн өмч		
2.3.1 Төрийн	0.00	0.00
2.3.2 Хувийн		
2.3.3 Хувьцаат		
2.3.4 Халаасны хувьцаа		
2.3.5 Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9 Хуримтлагдсан ашиг	6,369,413,330.33	6,495,777,594.38
2.3.10		
2.3.11 Эздийн өмчийн дүн	6,369,413,330.33	6,495,777,594.38
<b>2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,407,216,530.33</b>	<b>6,510,035,764.38</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)</b>		
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
<b>3. Нийт ашиг (алдагдал)</b>		
4. Түрээсийн орлого		
5. Хүүгийн орлого		
6. Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө		
7. Эрхийн шимтгэлийн орлого		
8. Бусад орлого	6,820,694,030.10	3,662,971,782.70
9. Борлуулалт, маркетингийн зардал		
10. Ерөнхий ба удирдлагын зардал	4,501,829,350.08	3,536,607,518.65
11. Санхүүгийн зардал		
12. Бусад зардал		
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17. Бусад ашиг (алдагдал)		
<b>18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>2,318,864,680.02</b>	<b>126,364,264.05</b>
19. Орлогын татварын зардал		
<b>20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>2,318,864,680.02</b>	<b>126,364,264.05</b>
<b>21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагд)</b>		
<b>22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>2,318,864,680.02</b>	<b>126,364,264.05</b>
<b>23. Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
<b>24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн</b>	<b>2,318,864,680.02</b>	<b>126,364,264.05</b>
<b>25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	4,050,548,650.31	4,050,548,650.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-
C03	<b>Залруулсан үлдэгдэл</b>	4,050,548,650.31	4,050,548,650.31
C04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-
C05	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
C06	Өмчид гарсан өөрчлөлт	-	-
C07	Зарласан ногдол ашиг	2,318,864,680.02	2,318,864,680.02
D01	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	<b>6,369,413,330.33</b>	<b>6,369,413,330.33</b>
D02	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-
D03	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	<b>6,369,413,330.33</b>	<b>6,369,413,330.33</b>
D04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	126,364,264.05	126,364,264.05

D05	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
D06	Өмчид гарсан өөрчлөлт		
D07	Зарласан ногдол ашиг		
D08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		
D09	<b>2025 оны 06-р сарын 30-ний үлдэгдэл</b>	<b>6,495,777,594.38</b>	<b>6,495,777,594.38</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		<b>0.00</b>
<b>1.1 Мөнгөн орлогын дүн</b>		<b>3,662,971,782.70</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого		3,662,971,782.70
<b>1.2 Мөнгөн зарлагын дүн</b>		<b>3,662,971,782.70</b>
Ажиллагчдад төлсөн		1,283,115,052.63
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		141,229,535.89
Бараа материал худалдан авахад төлсөн		80,435,325.00
Ашиглалтын зардал төлсөн		774,272,220.51
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		13,500,000.00
Хүүгийн төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн		
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага		1,370,419,648.67
Түрээсийн төлбөрт төлсөн		
<b>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>0.00</b>
<b>2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		<b>0.00</b>
<b>Мөнгөн орлогын дүн</b>		<b>0.00</b>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүгийн орлого		
Хүлээн авсан ногдол ашиг		
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>0.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>0.00</b>
<b>3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Мөнгөн орлогын дүн		
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		

Мөнгөн зарлагын дүн		
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>0.00</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		
<b>Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>0.00</b>
<b>Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>0.00</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4,732,461,700.00	3,260,281,114.70	1,472,180,585.00	69%
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,732,461,700.00	3,260,281,114.70	1,472,180,585.00	69%
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,732,461,700.00	3,260,281,114.70	1,472,180,585.00	69%
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,771,967,300.00	1,283,115,052.00	488,852,248.00	72%
210101	Үндсэн цалин	792,637,300.00	628,929,719.33	163,707,581.00	79%
210102	Нэмэгдэл	237,791,200.00	173,946,180.90	63,845,019.00	73%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	563,640,400.00	382,345,727.76	181,294,672.00	68%
210104	Урамшуулал	132,106,100.00	82,740,063.55	49,366,036.00	63%
210105	Гэрээт ажлын хөлс	45,792,300.00	15,153,360.69	30,638,939.00	33%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	239,215,200.00	141,229,535.89	97,985,664.00	59%
210201	Тэтгэврийн даатгал	168,336,900.00	93,956,945.91	74,379,954.00	56%
210202	Тэтгэмжийн даатгал	17,719,700.00	12,949,516.43	4,770,184.00	73%
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,175,500.00	7,902,789.01	6,272,711.00	56%
210205	Эрүүл мэндийн даатгал	35,439,600.00	22,515,496.07	12,924,104.00	64%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,166,547,000.00	774,272,220.51	392,274,779.00	66%
210301	Гэрэл, цахилгаан	847,723,800.00	498,069,451.83	349,654,348.00	59%
210302	Түлш, халаалт	184,053,200.00	148,667,968.79	35,385,231.00	81%
210303	Цэвэр, бохир ус	134,770,000.00	127,534,799.89	7,235,200.00	95%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	150,227,100.00	80,435,325.00	69,791,775.00	54%
210401	Бичиг хэрэг	15,759,100.00	8,475,160.00	7,283,940.00	54%
210402	Тээвэр, шатахуун	18,000,000.00	13,500,000.00	4,500,000.00	75%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,468,000.00	6,065,089.00	402,911.00	94%
210405	Ном, хэвлэл	40,000,000.00	10,419,776.00	29,580,224.00	26%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	70,000,000.00	41,975,300.00	28,024,700.00	60%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	6,000,000.00	5,940,000.00	60,000.00	99%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000,000.00	5,940,000.00	60,000.00	99%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,067,615,700.00	754,392,247.00	313,223,453.00	71%
210601	Багаж, техник, хэрэгсэл	54,350,000.00	13,319,000.00	41,031,000.00	25%
210602	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	15,000,000.00	12,331,500.00	2,668,500.00	82%
210604	Урсгал засвар	998,265,700.00	728,741,747.00	269,523,953.00	73%

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	290,919,400.00	223,334,364.63	67,585,035.00	77%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	232,219,400.00	183,281,064.63	48,938,335.00	79%
210803	Даатгалын үйлчилгээ	6,300,000.00	6,300,000.00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,400,000.00	987,000.00	413,000.00	71%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	600,000.00	159,500.00	440,500.00	27%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	50,400,000.00	32,606,800.00	17,793,200.00	65%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,400,000.00	32,606,800.00	17,793,200.00	65%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	79,940,000.00	47,324,739.00	32,615,261.00	59%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	79,940,000.00	47,324,739.00	32,615,261.00	59%
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,970,000.00	23,662,369.44	16,307,630.56	59%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,220,000.00	20,862,369.44	357,631.00	98%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,750,000.00	2,800,000.00	15,950,000.00	15%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,732,461,700.00	3,260,281,114.70	1,472,180,585.00	69%
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	4,732,461,700.00	3,260,281,114.70	1,472,180,585.00	69%
132001	Орон нутгийн төсвөөс	4,732,461,700.00	3,260,281,114.70	1,472,180,585.00	69%
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	0.00	26,100,000.00	26,100,000.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	26,100,000.00	26,100,000.00	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	0.00	1	1	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	0.00	67	56	
620001	Удирдах ажилтан	0.00	1	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	0.00	11	11	
620003	Үйлчлэх ажилтан	0.00	53	42	
620004	Гэрээт ажилтан	0.00	2	2	

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх цалингийн зардал ХХОАТ-ын тайланд тайлагнасан дүнгээс 11,172.6 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	1	11,172.6					1	11,172.6				
Үнэ төлбөргүй ирсэн 2,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.	1	2,000.0					1	2,000.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>13,172.6</b>					<b>2</b>	<b>13,172.6</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
НБББББ-д биологийн хөрөнгийн бүртгэлийн талаар тусгаагүй, биологийн хөрөнгийг бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.	1	880.0					1	880.0				
Хөрөнгийн ангилал зөрүүлэн 8,028.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.	1	8,028.0					1	8,028.0				
Барилга байгууламжийн үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ байхгүй байна.	1	-					1	-				
Өр төлбөрийн 14,258.2 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	14,258.2			1	14,258.2						
Газрын гэрчилгээ байхгүй байна.	1	-					1	-				
Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд 457,817.6 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн зөрчил илэрсэн	1	457,817.6							1	457,817.6		
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>480,983.8</b>			<b>1</b>	<b>14,258.2</b>	<b>4</b>	<b>8,908.0</b>	<b>1</b>	<b>457,817.6</b>		



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 493/А/271210

Улаанбаатар хот

НТАГ-2026/021/НА-СТА-ОНӨТҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын өглөг 14,258,170 (Арван дөрвөн сая хоёр зуун тавин найман мянга нэг зуун далан) төгрөгийн өр төлбөрийг төлөөгүй, үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7. "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын өглөгийг тулган баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, аудитын хэрэгжилтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ (Ш.Мөнх-Оргил), нягтлан бодогч (А.Нандин-Эрдэнэ) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
С.ГАНТӨГС  
Ц.ЦЭНД-АЮУШ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426091020



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 563/АудТ 1270

Улаанбаатар хот

2021-2026/021/НА-СТН-ОНӨТҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар ОНӨТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланд тусгаагүй 457,817,600.00 (дөрвөн зуун тавин долоон сая найман зуун арван долоон мянган зургаан зуу) төгрөгийн шууд худалдан авалт хийж, өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тус зөрчилийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохин байгуулахыг хориглоно", 38 дугаар зүйлийн 38.1-д "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-д "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426091057

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний тайланд хэрэгжилтийн үр дүнг тусгаж тайлагнаагүй, шууд худалдан авалт хийсэн, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Мөнх-оргил/, нягтлан бодогч /А.Нандин-Эрдэнэ/ нарт сахилгын хариуцлага тооцон, биелэлтийг 2026 оны 05 дүгээр сарын 29-ний өдрийн дотор Нийслэл дэх Төрийн Аудитын газарт ирүүлэхийг Чингэлтэй дүүргийн Засаг дарга /Н.Мандуул/-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ  
С.ГАНТӨГС  
Ц.ЦЭНД-АЮУШ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар